

Батлав. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга

_____ / _____ /

эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга)

_____ / _____ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

_____ ХХК-ийн захирал _____

***ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГ ДАХЬ БАРУУН
УРД САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ***

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар MV-022800 /

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар 6751571 /

Хянасан:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн _____

эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн) _____

Боловсруулсан:

_____ ХХК-ийн байгаль орчны хэлтсийн дарга эсхүл байгаль орчны мэргэжилтэн _____

Гарчиг

1. Төслийн танилцуулга
 - 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл
 - 1.2 Төсөл хэрэгжүүлэх үндэслэл
 - 1.3 Төслийн ерөнхий мэдээлэл
2. Төсөл хэрэгжиж буй бүс нутгийн байгаль орчин нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга
 - 2.1 Төслийн талбайн орчмын физик газарзүйн нөхцөл
 - 2.2 Гадаргын тогтоц, түүний эвдрэл, өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдал
 - 2.3 Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд
 - 2.4 Төсөл хэрэгжих нутгийн нийгэм, эдийн засгийн товч танилцуулга
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
 - 3.1 Төслийн гол болон болзошгүй нөлөөллийн тодорхойлолт
 - 3.1.1 Төслийн нөлөөллийн тодорхойлолт
 - 3.1.2. Байгалийн хам бүрдэлд өртөгдөх байдал
 - 3.1.3 Агаар орчны өртөгдөх байдал
 - 3.1.4 Хөрсөн бүрхэвч өртөгдөх байдал
 - 3.1.5 Геологийн хурдас, газрын доорх усны өртөгдөх байдал
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
 - 4.1 Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго
- 5.0 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
- 6.0 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- 7.0 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- 8.0 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
- 9.0 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- 10.0 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө
- 11.0 Хог хаягдлийн менежментийн төлөвлөгөө
- 12.0 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- 13.0 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө
- 14.0 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө
- 15.0 Гүйцэтгэлийн шалгуур
 - 15.1 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгтүүд : 1-27

Хавсралт материалууд

1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар хавсралтын хамт
3. 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний нүүр хуулбар
4. Уулын ажлын төлөвлөгөөний хавсралт маягтууд

1. Төслийн танилцуулга

1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл

Компанийн нэр:	“Эта Энжи” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011831131
Регистрийн дугаар:	6751571
Тусгай зөвшөөрлийн дугаар :	MV-022800 - “Баруун урд сайр”
Олгосон газар:	АМГТГ
Олгосон огноо:	2024 оны 05-р сарын 09-ний өдөр
Төслийн байршил:	Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сум
Талбайн хэмжээ:	165.46 га

1.2 Төслийн танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч “Эта Энжи” ХХК нь алтны таваарын бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох, олборлосон бага агуулгатай алтны хүдрийг дотооддоо баяжуулан, ажлын байр бий болгох, улс болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, МУ-ын валютын нөөцийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулахаар “Баруун урд сайр”-ын алтны ордын нөөцийг олборлон, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой.

Төсөл хэрэгжүүлэгч нь 2022 онд ордод хайгуулын ажлыг гүйцэтгэн, ажлын үр дүнд алтны нөөцийг тогтоон, үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2023 оны 03-р сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ЭБМЗ-ийн 2023 оны 03-р сарын 02-ны өдрийн ХХ-02-03 тоот дүгнэлт, ҮГА-ны даргын 2023 оны 07-р сарын 25-ны өдрийн Н/53 тоот тушаалаар ордын нөөцийг бодитой (В) зэрэглэлээр шлихээр 21.75 кг, химийн цэврээр 19.28 кг, боломжит (С) зэрэглэлээр шлихээр 0.95 кг, химийн цэврээр 0.85 кг, нийт шлихээр 22.70кг, химийн цэврээр 21.13 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн бол АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын 2024 оны 5-р сарын 9-ний өдрийн 176 тоот шийдвэрээр 165.46 га талбай бүхий MV-022800 дугаарт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг төсөл хэрэгжүүлэгч “ЭТА Энжи” ХХК-д олгосон байна.


ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН
ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.3 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр	“Баруун урд сайр”-ын алтны шороон ордыг ашиглах
Төслийн байршил	Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд 165.46 га талбайд хэрэгжихээр төлөвлөж байна.
Төсөл хэрэгжүүлэгч	Компанийн нэр: “Эта Энжи” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011831131 Регистрийн дугаар: 6751571 Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022800 “Баруун урд сайр” Оффис хаяг: УБ, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 104-р байр 20 тоот Утас: 99110596
Үйлдвэрлэлийн нөөц	Шлихээр 18.5 кг, химийн цэврээр 16.4 кг алт/гравитаци, 88.64% металл авалттай баяжуулах/
Олборлолтын хүчин чадал	90 мянган м ³ алт агуулсан элс олборлох
Техник эдийн засгийн үндэслэл хүлээн авсан дүгнэлт	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Ашигт малтмал, газрын тосны газар ЭБМЗ-ийн 2025 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн т/25-02-07 дугаар дүгнэлт
Техник эдийн засгийн үндэслэл хүлээн авсан тушаал	АМГТГ Даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр
Төслийн хугацаа	2 жил

Уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж, үйл ажиллагаа жигдэрснээр уурхайд төсөл хэрэгжүүлэгчийн 15, гэрээт компанийн 47, нийт 62 хүний ажлын байр бий болохоос гадна 2,968.4 сая төгрөгийн ажил үйлчилгээ, бараа материалын худалдан авах ажиллагаатай холбоотой шууд бусаар 50-100, түүнээс олон ажлын байр бий болгох буюу тухайн байгууллагуудын ажлын байруудыг баталгаажуулахад нөлөөлнө. Төсөл хэрэгжих хугацаанд 706.4 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөв, тусгай сангуудад төвлөрүүлнэ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН
ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

Хүснэгт 03. Лицензийн талбайн газарзүйн солбицол

№	Тэгш өнцгийн солбицол		Газарзүйн солбицол		Талбай, га
1	306027.8204	5083376.446	102° 25' 29.12" E	45° 48' 44.62" N	165.46
2	300584.8388	5083540.752	102° 24' 56.15" E	45° 48' 44.63" N	
3	300482.5467	5080364.809	102° 24' 56.12" E	45° 47' 29.37" N	
4	301131.5037	5080343.946	102° 25' 29.12" E	45° 47' 29.36" N	

2. Төсөл хэрэгжиж буй бүс нутгийн байгаль орчин нийгэм эдийн засгийн төлөв
байдлын товч танилцуулга

2.1 Төслийн талбайн орчмын физик газарзүйн нөхцөл

Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг Их мужийн Хангайн мужийн Сэлэнгэ, Орхон голын сав дахь бэсрэг уулсын тойрогт, геоморфологийн мужлалаар төв болон хойт хэсэг нь Хангай, Хэнтийн уулт өндөрлөг, өмнөд хэсэг нь Алтайн ар говийн цав толгодын мужид, инженер-геологийн мужлалаар Баянхонгор, Орхон-Сэлэнгэ, Өндөр шилийн мужид тус тус хамаарагдана.

Судалгааны талбай нь Хайрхандулаан, Тарагт сумуудын нутаг Цоорхой нэртэй газарт байрлах талбай нь Хангайн өмнөд бэгэлцэг мужид багтаж байна.

Өвөрхангай аймгийн нутаг газарзүйн 3 бүсийг хамрах тул байгалийн үлэмж баялагтай. Хангайн нурууны Хятруун, Битүүт, Монгол Алтайн нурууны Багабогд, Мянган ямаат зэрэг

далайн түвшнээс дээш 2000-3590 м өндөрт өргөгдсөн сүрлэг уул, нурууд оршдог. Мөн 24 метрийн өндрөөс буух Орхон голын "Улаан цутгалан", далайн түвшнээс дээш 2500 метрийн өндөрт орших байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт Хүйсийн найман нуур болон "Тамчийн ёл хад" зэрэг сонин сайхнаараа гайхагдсан газар тус аймагт олон байдаг.

2.2 Гадаргын тогтоц, түүний эвдрэл, өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдал

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутагт байрлах MV-022800 тоот ашигт малтал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь далайн түвшнээс дээш 1149-2270 метрийн үнэмлэхүй өндөрт, 5-300 налуужилттай байна. Монгол орны байгалийн бүс бүслүүрээр хээрийн бүсэд байрлана.

2.3 Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Өвөрхангай аймаг нь уур амьсгалын хувьд их газрын эрс тэс уур амьсгалтай. Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл сумын нутгийн ихэнх хэсэг нь хуурайдуу сэрүүхэн зунтай, өвөлдөө цас ихтэй байдаг. Хавар салхитай өдрийн тоо харьцангуй цөөн, зундаа хур тунадас багатай, налгар сайхан намартай ургамлын ургалт хавар эрт сайн байсан хэдий ч хур тунадасны хэмжээнээс шалтгаалан гандуу байдалтай жил байна.

Өвөрхангай аймгийн нутгийн хойноос урагшлах тутам дулаарч хур тунадас багасдаг. Жилийн агаарын дундаж температур хангайд -2.1 хэм, тал хээрт +1.0 хэм, говьд +3.7 хэм ба агаарын үнэмлэхүй их дулаан +44.8 хэм, үнэмлэхүй бага температур -47.5 хэмд хүрдэг. Жилд дунджаар хангайд 306.1 мм, тал хээрт 277.3 мм, говьд 117.2 мм тунадас ордог. Нутгийн хойноос урагшлах тутам дулаарч хур тунадас багасдаг. Жилийн агаарын дундаж температур хангайд -2.1 хэм, тал хээрт +1.0 хэм, говьд +3.7 хэм ба агаарын үнэмлэхүй их дулаан +44.8 хэм, үнэмлэхүй бага температур -47.5 хэмд хүрдэг. Жилд дунджаар хангайд 306.1 мм, тал хээрт 277.3 мм, говьд 117.2 мм тунадас ордог.

2.4 Төсөл хэрэгжих нутгийн нийгэм, эдийн засгийн товч танилцуулга

Аймгийн хэмжээнд суурин хүн амын тоо 117089 болж өмнөх оноос 0.1 хувиар буурчээ. Нийт хүн амын 49.7 хувь нь эрэгтэйчүүд, 50.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын хүйсийн харьцаагаар, 100 эмэгтэйд 99 эрэгтэй ногдож байна. Суурин хүн амын 30.5 хувь нь аймгийн төвд, 22.8 хувь нь сумын төвд, 46.7 хувь нь хөдөөд амьдарч байна. Сүүлийн жилүүдэд аймгийн төв рүү суурьших иргэдийн тоо нэмэгдсээр байна. 2022 онд хүн ам зүйн ачаалал улсын хэмжээнд 58.3 хувь байгаа ба аймгийн хэмжээнд 57.0 хувь байна. Өмнөх онтой харьцуулбал 0.1 нэгжээр буурсан байна. Аймгийн хэмжээнд нэг өрхөд дунджаар 3.4 хүн ногдож байна. Өрхийн 76.4 хувь нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, 23.6 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна. Нийт өрхийн 29.3 хувь нь аймгийн төвд, 23.2 хувь нь сумын төвд, 47.5 хувь нь хөдөөд амьдарч байгаагаас

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН
ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хайрхандулаан суманд нийт 3465 хүн ам байдаг бөгөөд аймгийн хэмжээнд нийт хүн амын 6%-ийг эзэлж байна.

Хүснэгт 04 . Хайрхандулаан сумын хүн амын тоо

Багийн нэр	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
1-р баг, Туяа	356	311	667
2-р баг, Арвайнтал	216	192	408
3-р баг, Хүрэмт	587	560	1147
4-р баг, Урт	183	179	362
5-р баг, Их булаг	155	149	304
6-р баг, Алтантал	198	175	373
Нийт	3261		

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

3.1 Төслийн гол болон болзошгүй нөлөөллийн тодорхойлолт

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан болон Эта энжи нутагт орших “Баруун урд сайр”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн ТЭЗҮ болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судлаж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг БОНХСайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дараах алхмаар тодорхойлов.

3.1.1 Төслийн нөлөөллийн тодорхойлолт

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр түүний орчмыг оруулсан агаар, сансрын зургийг бэлтгэж, тэдгээр дээр төсөл хэрэгжүүлэх байршил, түүний үйл ажиллагаа явагдах газар, объектуудыг тэмдэглэв

Тус лицензийн талбай нь нийт лицензийн 165.46 га газрын 10.1% буюу 16.76 га талбайн уурхайн ашиглалтын нөлөөлөлд өртөнө.

3.1.2. Байгалийн хам бүрдэлд өртөгдөх байдал

Тус ордын ашиглалтын үндсэн процессууд болох, малталт, нэврэлт, бэхэлгээ, өрөмдлөг-тэсэлгээ, ухаж ачих, тээвэрлэх /дотоод болон гадаад/ зэргээс ургамлан бүрхэвч, хөрсөн бүрхэвч, геологи, геоморфологи зэрэгт үзүүлэх нөлөөллийг тодорхойлохдоо давхцуулан зураглах аргыг ашиглав. Мөн агаар орчинд тархах тоос, тоосонцор болон бусад төрлийн эгэл хэсэг нь хүндийн хүчний нөлөөгөөр газрын гадаргад бууж хөрс, ургамлан бүрхэвчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Иймд агаар бохирдуулагч эх үүсвэрээс ялгарах бохирдуулагч бодисын тархалтыг тооцоолж, бохирдуулагч бодисын тархалтын хилээр нөлөөллийн бүсийг тодорхойлов. Бохирдуулагч бодисын тархалтыг дараах байдлаар тооцоолов. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийг таамаглаж, учирч болох

эрсдэлийг тооцоолж байгаа учир сөрөг нөлөөлөл нь чиг бүрд адил магадлалтай тархана гэж үзэж нөлөөллийн бүсийг татав..

3.1.3 Агаар орчны өртөгдөх байдал

Агаарын чанарт нөлөөлөх эх үүсвэрүүд:

А. Уурхайн тээврийн зам. Уурхайн гол агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь уурхайн тээврийн замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилт юм. Уурхайн тээвэрлэлт нь овоолго тээврийн хүнд даацын тээвэр болон үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бүрдэнэ. Тээврийн замаас үүсэх тоос, тоосонцрын ялгарлын хэмжээг АНУ-ын Байгаль орчныг Хамгаалах Агентлаг AP-42 section 13.2.2 Unpaved Road эх үүсвэрийн гарын авлагын аргазүйг ашиглан тооцоолов. Тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа нийт тоос, тоосонцрын 80%-с илүүг үүсгэдэг. Үйлдвэр дотоод тээвэрлэлт нь овоолго болон хүдрийн бункер хооронд хийгдэх хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн юм.

Б. Ухаш олборлолт. Уурхайн үндсэн үйл ажиллагаа буюу олборлолт уурхайн ухаш дотор явагддаг. Уулын цулыг утгуурт ачигч буюу экскаватороор тээврийн хэрэгсэлд ачихад хялбар болгохын тулд уурхайн хүдэр болон хөрсний биетэд өрөмдөж тэсрэх бодисоор тэсэлгээ хийнэ. Тэсэлгээгээр суларсан хөрс, хүдрийг тээврийн хэрэгсэлд утгуурт ачигчаар ачина. Өрөмдлөг, тэсэлгээ, ухаж ачих, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүснэ.

В. Овоолго үүсэх. Ухаш олборлолтоор тээврийн хэрэгсэл уулын цулыг уурхайн овоолго дээр тээвэрлэж буулгана. Тээврийн хэрэгсэлээс овоолгод материал буулгахад болон овоолго үүсгэх автомеханизм болох бульдозерийн үйл ажиллагаар орчны агаарт тоос, тоосонцор ялгарна

Г. Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагч. Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг. Түлшний найрлаганд агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч, дэгдэмхий органик нэгдлүүдээс шаталтаар агаарт хүхэрийн ислүүд, нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд, метан болон метан агуулаагүй ууршимтгай органик, нэгдлүүд болон азотын ислүүд ялгардаг.

Уурхайн агаар бохирдуулагч бодисын ялгарлын тооцоолол/emission inventory/

Уурхайн үйл ажиллагаанаас үүсч байгаа агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээг ялгарлын тооцоолол буюу ялгарлын инвентор ашиглан тооцоолдог. Ялгарлын инвентор гэдэг нь агаар бохируулагч эх үүсвэрээс ялгарсан агаар бохирдуулах бодисын

ялгарлын хэмжээг тооцоолон гаргаж, эх үүсвэр тус бүрээр нэгтгэсэн ялгарлын бүртгэлийг хэлэх бөгөөд энэ нь агаарын бохирдлыг бууруулах бодлого, арга хэмжээг сонгох, үр дүнг үнэлэх, тодорхойлоход зайлшгүй шаардлагатай чухал мэдээлэл болдог. Ялгарлын инвенторыг дараах зорилгоор ашигладаг. Тооцооллын аргаар болон бодит хэмжилтээр ялгарлын хэмжээг тодорхойлох нь агаарын бохирдлын гол эх үүсвэрийг олж тогтоон, тухайн эх үүсвэрт тохирсон ялгарлыг бууруулах арга хэмжээний сонголт, бодит үр дүнгийн үнэлгээг хийх боломжийг бүрдүүлдэг. Мөн ялгарлыг тооцоолох явцад эх үүсвэрийн мэдээлэл, өгөгдлийн дутагдалтай байдал, тэдгээр мэдээллийг цуглуулахад чиглэсэн судалгаа хийх шаардлага, ач холбогдлыг тодорхойлох боломжтой болдог. Ялгарлын инвенторыг агаар орчны тархалтын загварчлалын оролтын өгөгдөл болгон ашиглаж, агаарын бохирдлын орон зайн болон цаг хугацааны тархалтыг тооцоолдог.

Загварчлалын тооцооллын дүнг бодит хэмжилтийн дүнтэй харьцуулж үнэлдэг. Мөн загварчлалаар тодорхойлсон ялгарлын хэтийн төлөв байдлын тооцооллын дүнг ашиглан ялгарлын стандартыг хангахад чиглэсэн бохирдуулах бодисын ялгарлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, төлөвлөх боломжтой болдог. Ялгарлын инвенторыг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд нэвтрүүлэх технологийг сонгохдоо тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнөх ба дараах үеийн ялгарлын өөрчлөлтийн хэмжээтэй харьцуулж, үр дүнг үнэлэхэд ашигладаг. Энэ нь төрөл бүрийн технологи нэвтрүүлэх зардлыг тэдгээрийн ялгарлын өөрчлөлтийн үр дүнтэй харьцуулж үнэлсэнээр зардалтай харьцах үр дүн өндөртэй технологийг сонгох боломжийг бүрдүүлдэг. Ялгарлын фактор гэдэг нь бохирдуулагчийн ялгарлын эрчмийн статистик дундаж буюу ямар нэг үйл ажиллагаанаас агаарт цацагдсан бохирдуулагчийг тухайн үйл ажиллагааны түвшнөөр үржүүлсэн үзүүлэлт юм.

Энэхүү ялгарлын фактор нь нэгж тн эрдэс түүхий эд олборлоход эсвэл нэгж тонн эрдэс чулуулаг бутлах гэх мэт үйл ажиллагаануудаас үүсэх бохирдуулагчийн тоо хэмжээгээр илэрхийлэгдэнэ. Уурхайгаас үүсэх нийт бохирдуулагчдын хэмжээ нь эх үүсвэр тус бүрийн ялгарлын факторыг эх үүсвэр тус бүрийн тоогоор үржүүлж нэмсэнтэй тэнцүү байна. Эх үүсвэрээс ялгарах ялгаралын факторыг тооцоход АНУБХА-AP42 (USEPA - AP42). Австрали улсын (NPA Emission estimation technique manual for mining ver3.1) нүүрсний ил уурхайгаас үүсэх тоосонцрын хаягдлын факторуудын тооцох аргазүй болон төслийн ТЭЗҮ-гын мэдээллийг тооцоонд ашиглав.

Уурхайн тээврийн замаас үүсэх тоосжилт. Сайжруулаагүй зам эсвэл замгүй хэсгээр тээврийн хэрэгсэл зорчих үед дугуйн даралтын хүчний үйлчлэлээр гадаргуун материал хэмхэрч нунтгардаг. Тээврийн хэрэгсэл зорчин өнгөрөх үед түүний ард дагалдан үүсдэг

агаарын хүчтэй турбулент хөдөлгөөний үйлчлэлээр замын гадаргуун материалын эгэл хэсгүүд хөдөлгөөнд орох эргэлдэж буй дугуйгаар зарим хөрсний эгэл хэсгүүд дээш өргөгдөх болон зарим эгэл хэсгүүд доош унах зэргээр тоосжилт үүсдэг. Замын тухайлсан хэсгээс үүсэх тоосжилтын хэмжээ нь замын ачааллаас шугаман. замын гадаргын материалын шаварлаг(75 микроноос бага диаметртэй хөрсний бүрэлдэхүүн хэсэг)-ийн агууламжаас шууд хамааралтайгаар өөрчлөгддөг. Шаварлагийн агууламж нь газарзүйн байршлаас хамааран өөрчлөгддөг. Уурхайн бүсэд хүнд даацын тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн үүсгэх тоосжилт нь тэдгээрийн жинтэй нэлээд хамааралтай байдаг ба уурхайн бүсэд сайжруулсан шороон замаар тээврийн хэрэгсэл зорчих үед үүсэх тоосонцорын хэмжээг дараах эмпирек томъёогоор тооцоолно.Уурхайд тээвэрлэлтэнд Howo 290 маркийн автосамосвалууд ашиглахаар төлөвлөсөн. Тээвэрлэлтээс үүсэх хамгийн гол агаар бохирдуулагч бодис тоос,тоосонцрын ялгарлын хэмжээг доорх аргазүй ашиглан тооцов.

3.1.4 Хөрсөн бүрхэвч өртөгдөх байдал

Тусгай зөвшөөрлийн талбай нь нам уулсын хажуу, хөндий газар байрлах учраас тал хөндийн хар хүрэн хөрсний бүлгийн ердийн хүрэн, сайргархаг хөрс тархсан байна

.

4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

4.1 Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Тус байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт нь Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Эта Энжи” ХХК-ийн “Баруун урд сайр”-ын алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүний сөрөг үр дагавар, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тогтоох явдал юм.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлов.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ								
Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар	Тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Уурхайн бүсэд	төг	200,0	10	2,000,0	4 р улиралд	Агаарын тухай хууль,
	Шатах тослох материалд чанарын хяналт тавих	Уурхайн бүсэд					2025 он	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Уурхайн дотоод тээврийн замуудыг эвдрэл гарсан тухай бүрд сэргээн засварлах	Уурхайн бүсэд					2025 он	Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998
	Зам талбайн тоосжилтыг бууруулах, дотоод тээврийн зам, хөрсний овоолгоос үүсэх тоосжилтийг бууруулах усалгааг хийх			Үйл ажиллагааны зардалд тусгасан				
Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Уурхай, овоолго, ауулах, суваг шуудуу, зам талбайг ажлын зургийг дагуу барих, байгуулах, машин механизмын замыг трассын дагуу тавих, тэдгээрийн хөдөлгөөний хянах	Уурхайн бүсэд	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан			2025 он	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль . 3Г – ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт. Ус ашиглалтын төлбөрийн хувь хэмжээ
	Гүний худагт усны тоолуур суурилуулах	Уурхайн худаг	Төг	50.0	1ш	50.0	2025 он	
	Боловсон ариун цэврийн байгууламж байгуулах	уурхайн бүсэд	төг	20,000,0	1ш	20,000,0	2025 он	
Хөрсөн бүрхэвч	Эвдрэлд орсон зарим замыг тэгшилж шимт хөрсөөр хучиж ,	Нийт ашиглалтын талбай	төг	600	1,2 га	750,0	2025 он	MNS 3307: 1991 ,MNS 3308:1991 Хөрсний химийн

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийнэ.							элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга .
	Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Уурхайн талбайд	-	-	-	-	-	
Газрын хэвлий	Ил уурхайн зам талбайд хэрэглэсэн дайрганы карьерыг хэсэгчлэн булж тэгшилнэ.	Нийт ашиглалтын талбай	төг	1930	0,1	1900,0	2025 он	MNS 5850:2008 хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5915:2008
Ургамлан нөмрөг	Үржил шимт хөрсийг хуулж 5-м өндөргүй овоолго үүсгэн хадгална.	Олборлолтонд өртөх талбайн хэмжээнд	төг	-	-	Үйл ажиллагааны зардалд	2025 он	MNS 5850:2008 хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5915:2008
Амьтны аймаг	Уурхайн бүсд болон ойр орчимд амьдарч буй мал , зэрлэг ан амьтдыг олборлолтын үйл ажиллагааны явцад , аюул ослоос хамгаалж уурхайн бүсээс холдуулах, ажилчдад хууль тогтоомж танилцуулах	Ашиглалтын талбайн хэмжээнд	төг	-	-	Үйл ажиллагааны зардалд	2025 он	
Нийт						24,700,000		

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян төг	Нийт зардал, төг Мян төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	Тухайн жилийн олборлосон. талбайг дотоод овоолгоор дүүргэж тэгшилнэ .	га	-	-	-	2025 онд	MNS5916-2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах ,хадгалах техникийн шаардлага .
2.	Биологийн нөхөн сэргээлт	Тухайн жилийн олборлосон талбай 2,0 га талбай	га	-	-	-	2025 онд	MNS5917-2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт Техникийн шаардлага
3.	Татан буулгах, хаалтад бэлтгэх		%	-	-	0,0	2025 онд	MNS5918-2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага . MNS4920-2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага .
	Нийт					0,0		

2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө төлөвлөгдөөгүй болно.

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мянтөг	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	-	Өвөрхангай аймаг аймаг .Хайрхандулаан сум, Хан-Хөгшин хайрханы зэрлэг амьтдад 20 боодол өвс, 500 кг хужир тавьж биотехникийн арга хэмжээ авах	-	-	28,522,665	Судалгааны үр дүнгээр	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын саналд үндэслэж төлөвлөсөн.
	Нийт					28,522,665		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашиглалтын талбай нүүлгэн шилжүүлэх айл өрх байгүй учир БОННҮ-ний тайланд Нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговрын талаар төлөвлөгдөөгүй.

8.1 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 20

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Үйл ажиллагааны явцад олборлолтын талбайн хэмжээнд суурьшиж буй айл өрх байхгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй	Нүүлгэн шилжүүлэх ажиллагаа хийгдэхгүй	Өвөрхангай аймаг Хайрхандулаан сум	-	-	-	2025 он	
	Нийт							

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

7.1 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 21

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Археологи , угсаатны зүйн судалгаагаар тогтоогдсон дурсгалт газруудыг хамгаалах / ашиглалтын талбайд дурсгалт газар тэмдэглэгдээгүй байна /	Ашиглалтын талбайн хэмжээнд	-	-	-	2025 он	Ашигт малтмалын тухай хууль
2.	Палеонтологийн дурсгал	Палеонтологийн авран хамгаалах судалгааны ажил / палеонтологийн олдвор бүхий цэг тогтоогдоогүй болно /	Ашиглалтын талбайн хэмжээнд палеонтологийн олдвор илрээгүй болно .	-	-	-	2025 он	Ашигт малтмалын тухай хууль
	Нийт			-	-	-		

10.0 ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Химийн бодисийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээнийн төлөвлөгөөг боловсруулж ажиллана. Тус ангилан ялгах үйлдвэрт ямар нэгэн химийн бодис хэрэглэгдэхгүй боловч хүнд даацын тэрэг техникийн шатах тослох материалаас үйдэлтэй химийн бодис асгарах алдагдах зэрэг эрсдэл гарах магадлалтай юм.

10.1 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 22

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян төг/	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Болзошгүй осол, саатал , баяжуулах тоног төхөөрөмжийн гэмтэл үүсэх	Техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж , хянах , хяналтын ажилтан томилж ажиллуулах	Ил уурхайн баяжуулах төхөөрөмж , усан сангийн насос	2	100,0	200,0	Үйл ажиллагааны явцад	Гамшгаас хамгаалах тухай хууль 27,1 Ил уурхайн аюулгүй ажиллагааны төлөвлөгөө
2.	Галын гэнэтийн аюул үүсэхээс урьдчилан сэргийлэх	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний заалт бүхий зурагт хуудас тараах , гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах	Уурхайн тосгон засварын газар, угаах төхөөрөмж , гал унтраах хэрэгсэл	Галын хор 8ш	100.0	800,0	Үйл ажиллагааны турш	
3.	Байгалийн гамшиг , түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх түүнийг боловсруулах	Ашиглалтын талбайн хэмжээнд	-	50,0	50,0	Үйл ажиллагааны турш	
	Нийт					1,050,000		

11. ХОГ ХАЯГДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллана. Мөн хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, аюултай хог хаягдлаар нь ангилан ажиллахаар төлөвлөсөн.

11.1 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Уурхайн тосгон,гал тогоо ажилчдын ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын саванд хадгалан төвлөрсөн цэгт хаях , тушаах	Уурхайн тосгон	кг	100,0	2	200,0	2025 он	MNS3307: 1991 , MNS3308:1991 Хөрс, Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга . MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис , элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5915:2008
		Ажилчдын унд ахуйгаас гарах шингэн хаягдлыг бетонон доторлогоотой түр хадгалах хоногт 12 м3 бохир ус цэвэршүүлэх багтаамжтай цооног байгуулах, эсвэл бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах	Төслийн талбайд	ш	43,500,0	1	43,500,0	2025 он	
2.	Үйлдвэрийн	Засварын талбайг эфель , хайргаар хучиж газрын гадарга хөрс бохирдохоос сэргийлэх	Засварын талбай	м²	2000,0	1	2000,0	2025 он	
3.	Аюултай	Тослох материал , ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалж буцаан тээвэрлэж төвлөрсөн цэг	Засварын ажил	л	1	200	200,0	2025 он	
	Нийт						47,150,000		

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

12.0 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР								
№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, мян төг	Нийт зардал, мян төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн үйл ажиллагаана ас орчинд тоосжилт үүсэх , тархах	Ил уурхайн талбай хөрсний овоолго 5 цэгт	Жилд 1 удаа	Шинжилгээний зардал 1 удаагийнх 100мян төг 5*120 = 500 мян төг	600,0	Жил тутамд	MNS4585:2016 Агаарын чанар . Техникийн ерөнхий шаардлага MNS 3384: 1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048: 1988 тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11: 1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотокалориметрийн арга . MNS5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин . Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга . MNS5014: 2009 Дизель хөдөлгүүртэй автомашин .Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа , эрүүл ахуй . Шуугианы норм , аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226: 2003 Дуу чимээ – хэвийн норм , түвшний хэмжээ
2.	Дуу шуугиан чичиргээ	Машин механизмын ажиллагаа , хөдөлгөөнөө р шуугиан үүсэх	Хүнд даацын машины тээврийн зам , үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим 1 цэгт	Улиралд 1 удаа	Багажийн түрээсийн зардал 1 багаж 126.0 жилд 1 удаа	126,0	Жилд 1 удаа	
3.	Хүнд металлын агууламж	Түлш тосолгооны материал болон химийн бодис , хог хаягдлаар хөрс бохирдох	Дээрх 1 цэгт	Хагас жил тутамд	1 цэгт х2 дээж х жилд 1удаа х150,0	300,0	Улиралд 2 удаа	MNS 3307:1991 , MNS3308:1991Хөрс , Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга . MNS 3309: 1991 Хөрс , Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга . MNS 3675: 1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга . MNS 4006:1987 Хөрс . Хөдөлгөөнт фосфор , калийг тодорхойлох MNS 3298: 1991 Хөрс . Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага . MNS ISO 11047 : 2001 Хөрсний чанар . Хөрсний усан орчны хандмалд кадми , хром , кобальт , зэс , хар тугалга мангани , никель , цайрыг тодорхойлох , Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга . MNS58505: 2008 Хөрс бохирдуулагч бодис , элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ .

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.	Усны чанар рН ууссан нийт давс Усны түшин хэмжих	Төслийн талбай орчим	Гүний худгууд	Жилд 1 удаа	1 худагаас 1 дээж 1 худагийг 2 удаа	300,0	Жилд 1 удаа	MNS (ISO)4867: 1999 Усны чанар . Дээжийг боловсруулах , хадгалах хамгаалах MNS (ISO)4867: 1999 Усан орчин чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага . MNS (ISO)5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх , гарын авлагын зөвлөмж . MNS 13,060,50 Усны чанарын стандарт MNS 0900: 2005 Ундны ус . Эрүүл ахуйн шаардлага , түүнд тавих хяналт
5	Эргэлтийн усан сангаас дээж авч шинжилгээнд хамруулах	Төслийн талбайгаас	Усан сангаас	Жилд 1 удаа	Эргэлтийн усан сан, цэвэр усны нуураас	200,0	Жилд 1 удаа	MNS 13,060,50 Усны чанарын стандарт MNS 0900: 2005 Ундны ус . Эрүүл ахуйн шаардлага , түүнд тавих хяналт
	Хөрсний агрохимийн үзүүлэлт Хөрсний хүнд элементүүд	Уурхайн талбайд	Засварын талбай	Жилд 1 удаа	Уурхайн талбайн орчимд 2 цэгт	400,0	Жилд 1 удаа	MNS 3298:1991. MNS 5850:2019. MNS 3985:1987. MNS 3310:1991. MNS 2305:1995. MNS 2305:1994.
7	Хөрсний агрохимийн үзүүлэлт	Уурхайн талбайд	Уурхайн орчимд	Жилд 1 удаа	Уурхайн талбайн орчимд 5 цэгт	500,0	Жилд 1 удаа	
	Нийт					2,426,000		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын нийт зардлын дүн

13.0 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын бүтэц нүсэр биш учраас байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт зэрэг байгаль орчинтой хамааралтай ажлыг уурхайн ерөнхий инженер хариуцан гүйцэтгэнэ. Иймээс байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд туссан ажлыг төрөлжүүлэн зохион байгуулах арга хэмжээг хэрхэн авах талаар хувиарлав.

13.1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага
зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв / мян төг /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 10	Сар 11	Сар 12		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж мэргэжлийн байгууллагаар боловсруулж батлуулж байх	2600,0		+		Инженер	БОМТ болон Хяналт шинжилгээний гүйцэтгэлийг хэлэлцэх
2	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	1000.0			+	Инженер	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх
3	Ажлын байранд эмийн сан байршуулах	1450.0		+		Инженер	-
3	Нийгмийн нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах	2,000,0			+	Захирал	-
	Нийт	7,050,000					

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН УРД САЙР” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

14.0 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН
ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Өвөрхангай аймгийн БОАЖГ ын мэргэжилтэн “ЭТА Энжи “ ХХК- ийн байгаль орчны мэргэжилтэн , инженер Сумын байгаль орчны байцаагч , багийн дарга , иргэдийн төлөөлөл	Тайланг бичгэн хэлбэрээр орон нутаг , уурхайн талбай дээр очиж хэмжилт хийж баталгаажуулах .	Тухайн жилийн БОМТ ны хэрэгжилтийг хянах	2025 оны 4 - р улирал	200,0	Компаний инженер , байгаль орчны мэргэжилтэн	Өвөрхангай аймаг Хайрхандулаан сум Уурхай
	Нийт				200,000		

15. Дүгнэлт

“ЭТА Энжи” ХХК нь Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх “Баруун урд сайр” алтны шороон ордыг ашиглах төслийг 2025 оноос олборлолтын ажлыг эхлүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

2025 онд уурхайн ашиглалтын үйл ажиллагаатай уялдуулан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **111,098,665 төгрөг** зарцуулахаар төлөвлөв.

15.1 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Зардлын хэлбэр	2025
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24,700,000
Нөхөн сэргээлтийн зардал	-
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	28,522,665
Биологийн нөхөн сэргээлтийн зардал	-
Уурхайн хаалтын зардал	-
Хог хаягдлын менежментийн зардал	47 150 000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	2,426,000
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	1,050,000
Удирдлага, зохион байгуулалтын зардал	7,050,000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний зардал	200,000
НИЙТ	111,098,665